

Дундговь аймгийн Засаг даргын Боловсрол шинжлэх ухааны сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 12

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Боловсрол шинжлэх ухааны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Боловсрол шинжлэх ухааны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 74 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар арга хэмжээний хэрэгжилт 95,4 хувьтай байна. Үүнээс 100 хувь-66, 66.6 хувь-4, 65 хувь-1, 50 хувь-2, 30 хувь -1 байна.

Хавсралтаар 44 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт тооцон гаргахад 92.2 хувьтай байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Оюунлаг, МУБИС-тай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд багш нарын мэргэжлийн онол, арга зүйг дээшлүүлэх 2 удаагийн сургалт, цахим болон танхимын сорилуудыг зохион байгуулж, 17 судлагдахууны 597 багш нар мэргэжлийн онол арга зүй мэдлэгээ дээшлүүлсэн байна. Мөн 350 сурагч, 10 чиглэлээр 10

удаагийн сорилд хамруулсны үр дүнд Дундговь аймаг ЭЕШ-2023 шалгалтын нийт шалгуулагчид өнгөрсөн жилийн дундаж оноогоо математик 9,1 оноо, монгол хэл 3,3 оноо, нийгмийн ухаан 8,2 оноо, хими 14 оноо, биологи 4,3 оноогоор ахиулж, физик өнгөрсөн жилийн амжилтаа хадгалж, 6 судлагдахуун дундаж оноогоороо улсад 1-10-р эрэмбэлэгдсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан мэргэжлийн багш нарын багийг урамшуулах журмыг шинээр боловсруулан баталж, журмын дагуу элсэлтийн шалгалтад амжилттай дүн үзүүлсэн 40 багшид 110.0 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.



1. Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр



Сургалтын нэр: Мэргэжлийн багш нарыг чадавхижуулах

Зорилго: Багш нарын онол арга зүй дээшлүүлэх, оноог ахиулах, харилцан туршлага солилцох

Оролцогчдын тоо: ЕБС-ийн 597 багш

Сургалтын давтамж: 3 удаа

Хамтрагч байгууллагууд: АЗДТГ, БШУГ МУБИС, Шинэ эрин, Оюунлаг сургуулиуд ЕБС

ЭЭШ-ын 6 хичээлээр өмнөх оны оноо ахисан

2 суралцагч 800 оноотой шалгагдсан. /Монгол хэл, Түүх/

2 суралцагч 800 оноотой СУ шалгалт

40 багшийн урамшуулал

2. Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр

“ЭЭШ-800” ПРОГРАММ ДАТА АНАЛИЗАД СУУРИЛСАН СОРИЛ



ЭЭШ-800 программ ашиглан ЭЭШ-ын 10 хичээлээр нийт 6 удаагийн сорилыг онлайнаар зохион байгуулж үр дүнд анализ хийн ажилласан.

Системээс судлагдахуун бүрийн даалгаварт анализ хийж агуулгуудыг эрбэлж өгсөн.

Энэ нь ЭЭШ-д бэлтгэж байгаа багш нарт аль агуулгаар дэвтлэг хичээн орох баримжааг өгч байгаа нь системийн давуу тал байна.

8. “ЭЭШ-800” программ ашиглан ЭЭШ-ын 10 хичээлээр нийт 6 удаагийн сорилыг онлайнаар зохион байгуулж үр дүнд анализ хийн ажилласан. Системээс судлагдахуун бүрийн даалгаварт анализ гаргаж байгаа нь ЭЭШ-д бэлтгэж байгаа багш нарын ажил ачааллыг хөнгөвчилсөн_хүүхэд бүртэй тулж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн нь системийн давуу тал байлаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, 6,0 САЯ УТ

1. Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр

2. Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Дундговь чанар” Боловсролын чанар” хөтөлбөрийн хүрээнд МУБИС, Оюунлаг сургуультай байгуулсан “САНАМЖ БИЧИГ” байгуулан ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн багш сургалтыг үе шаттай сургалтыг явуулж, 597 багш нар хамрагдан, мэргэжлийн онол арга зүй мэдлэгээ дээшлүүлсэн байна.




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ -7,6 сая төгрөг



2022 он- 80 сурагч 40,0 сая

2023 он-Амжилттай дүн үзүүлсэн 700 -гаас дээш оноо авсан 21 сурагчид тус бүр 500,000 төгрөгийн урамшуулал нийт 12,5 сая олголоо.

ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ.12,5 САЯ ТӨГРӨГ

Залуу багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлж байгаа хичээлийн арга зүйн шинэ санааг эрэлхийлэх, харилцан туршлага солилцох, суралцах, багшийн ур чадвар хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, технологийн сан бүрдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 1-5 жил ажилласан багш нарын дунд “САЙН ХИЧЭЭЛ-2023” арга хэмжээ зохион байгуулав. Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарын 27.8 хувь буюу 138 багш 1-5 жил ажиллаж байгаагаас ур чадварын уралдаанд 100 багш буюу 72.5 хувь нь, цэцэрлэгийн 99 багшийн 22 хувь буюу 22 багш оролцон, хичээл зааж арга зүйгээ харилцан солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсон.



5. Залуу багш нарын, багшийн ур чадвар хөгжлийг дэмжих, харилцан туршлага солилцох зорилгоор сургууль, цэцэрлэгт 1-5 жил ажиллаж байгаа багш нарын дунд “САЙН ХИЧЭЭЛ-2023” арга хэмжээ зохион байгууллаа. Уралдаанд багш нар 100 хувь хамрагдсан үр дүнтэй ажил боллоо.



ЕБС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиад 13 хичээлээр явагдаж нийт 731 хүүхэд оролцон мэдлэг чадвар, оюун ухаанаа сорьсон өмнөх үеийнхээс 10 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна. Үүнээс 11 судлагдахуунд-731 суралцагч, монгол хэл-9-р ангийн анги нийтийн олимпиадад - 790, нийт 1521 суралцагч оролцжээ.



Хамгийн их зардал материал шаардагддаг техник технологийн олимпиадад оролцогч багш сурагчдад дэмжлэг 4,0 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.



Улсад гаргасан багш нарын амжилтууд -4 багш

№	Сургуулийн нэр	Багшийн нэр	Албан тушаал	Олимпиадын төрөл	Улсад үзүүлсэн амжилт
1	Баянжаргалан сумын ЕБС	Б.Намшир	Түүхийн багш	Түүх	Улсад 3-р байр
2	Цэгц билиг	Т.Мөнхбат	Нийгмийн ухааны багш	нийгмийн ухаан	Улсад Тусгай байр
3	ГИЦС	Э.Тогоожуу	МХУЗ-ын багш	монгол хэл	Улсад 2-р байр
4	Цэгц билиг	М.Ганбагана	МХУЗ-ын багш	монгол хэл бичиг	Улсад 2-р байр

Улсад гаргасан сурагчдын амжилтууд -4 сурагч

№	Сургуулийн нэр	Сурагчийн нэр	Анги Булг	Олимпиадын төрөл	Улсад үзүүлсэн амжилт	Бэлтгэсэн багш
1	Дэлгэрхонгор ай ЕБС	Б.Эрдэнэтуул	12а	Түүх	Улсад 2-р байр	М.Наранчимэл
2	Цэгц билиг	Ө.Цэрэннадмид	12а	Техник технологи	Улсад 3-р байр	Л.Оюунгэрэл
3	ГИЦС	Н.Буянхишиг	12а	Монгол хэл бичиг	Улсад тусгай байр	Э.Тогоожуу
4	Цэгц билиг	М.Номин	12б	монгол бичиг	Улсад тусгай байр	М.Ганбагана

ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ: Амжилт гаргасан багш, сурагчдын шагнал 4,0 сая төгрөг



Хөрөнгийн хэмжээ: 2,0 сая хандив



Арга хэмжээний нэр: Г.Батбаатар багшийн нэрэмжит аймгийн физикийн олимпиад



Оролцогчид: 20 багш, 6-12-р ангийн 150 сурагч



Ивээн тэтгэгч: ГИЦС-ийн Г.Батбаатар багштай 1993 оны төгсөгчид



Хамтран ажиллагч: АЗД, БШУГ, физикийн багш нар

"Явуулын сэтгэлзүйч" өдөрлөг

ГИЦС ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

"Сэтгэл хөдлөлөө удирдах нь" сургалт-133 хууцэд 17-12 анги!

Ганцаарчилсан зөвлөгөө: 12 хууцэд 3 жил эх

Боловсролын сэтгэлзүйч Б.Саранзаяа

"ЖУУМЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ"-ийн өдөрлөг

2023 оны 04 дүгээр сарын 26-28-нд

Мандал сургуулийн сэтгэл зүйч Б.Саранзаяа нь Политэхник коллежийн хүүхэд, эцэг, эхчүүдэд ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө, сэтгэлзүйн сурвалт зохион байгуулна.

ЭМЭД ДАМАГААС ОУЛСЛУУСГАРВАЛ ДЭМЖЭГДЭХЭЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ (ХИМБЭРИ)

- Хүн ажилтай ИВАЛЦМААР танилцвал...
- Хүн ажилтай ойшлогоос ХАРИУДАЖ ивэлдүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж...
- Хүн ажилтай ОЙШЛОГООС ХАРИУДАЖ ивэлдүүлж...

Хүүхдийнхээ суралтын өдөрлөг, сэтгэл зүйн байдал, суралтын өдөрлөг, сэтгэл зүйн байдал, суралтын өдөрлөг...

Сэтгэл зүйн зөвлөгөөний цаг авах утас: 996264922

Боловсролын Сэтгэлзүйч Г.Отгонсүрэн

"ЖУУМЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ"-ийн өдөрлөг

2023 оны 04 дүгээр сарын 26-28-нд

Мандал сургуулийн сэтгэл зүйч Г.Отгонсүрэн нь жуулын сэтгэлзүйч өдөрлөгийн хүрээнд Говийн ирээдүй сэтгэлзүйн сургуулийн хүүхэд, эцэг, эх асран хамгаалагч нар, сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөө, сэтгэл зүйн сурвалт зохион байгуулна.

ЭМЭД ДАМАГААС ОУЛСЛУУСГАРВАЛ ДЭМЖЭГДЭХЭЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ (ХИМБЭРИ)

- Хүн ажилтай ИВАЛЦМААР танилцвал...
- Хүн ажилтай ойшлогоос ХАРИУДАЖ ивэлдүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж, 10-р удаа захирагчид хэлэлцүүлж...
- Хүн ажилтай ОЙШЛОГООС ХАРИУДАЖ ивэлдүүлж...

Хүүхдийнхээ суралтын өдөрлөг, сэтгэл зүйн байдал, суралтын өдөрлөг, сэтгэл зүйн байдал, суралтын өдөрлөг...

Сэтгэл зүйн зөвлөгөөний цаг авах утас: 80779951

Эрхүүгийн Үндэсний Судалгааны Техникийн Их Сургуульд орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх зуны сургалтад Сайнцагаан сумын Цэгц билиг

сургуулиас 2, Баянжаргалан, Дэрэн, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 4, нийт 6 багш "Орос хэлний сургалтад орчин үеийн дэвшилтэт технологийг хэрэглэх арга зүй" сургалт, Оросын Сибирийн бүс нутгийн өв соёл, зан заншилтай танилцаж 21 хоног суралцаад ирлээ. Мөн хичээлийн судалгааны чиглэлээр Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран Япон улсад Мандал сургуулийн 6 багш, нийт 13 багш, удирдах ажилтан мэргэжлээ дээшлүүлэхэд 13.8 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн.



Сайнцагаан сумын 5-р цэцэрлэг, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэгийн гадаад тоглоомын талбайг иж бүрэн тохижуулах ажлыг орон нутгийн 119.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн.





Арга хэмжээний нэр: 4.1 Үндэсний бичиг үсгийн баяр-2023 хичээлээр



Зорилго: Иргэд, суралцагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах



Арга хэмжээний тоо: 6



Оролцогчдын тоо: Иргэд, суралцагчид төрийн албан хаагчид-1595



Хамтрагч байгууллагууд: АЗД, АЗДТГ Хэлний бодлогын салбар зөвлөл, БШУГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ: 5,3 сая төгрөг

Иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадварын боловсролыг дээшлүүлэх



Төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг танхимаар 430, цахимаар 230 нийт 660 хүнд зохион байгууллаа. Мөн 2200 иргэд, төрийн албан хаагчдад цахимаар алсын хараа 2050 урт хугацааны бодлогын цахим контент сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж гэрчилгээ олгосон. Нийт 2860 иргэн, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсролд аймгийн Засаг даргын 12,5 сая төгрөгийн дэмжлэгээр “Сайн багш-сайн цэцэрлэг” аяныг явуулж, багш нараа урамшууллаа.

1. Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр



1. Сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг дарга, БШУГ-тай хамтран “Сайн багш-Сайн цэцэрлэг” арга хэмжээний удирдамжийг хэрэгжүүлэн ажиллаж, 15 багш, 3 цэцэрлэгийг шалгаруулан урамшуулаад байна.

Ерөнхий боловсролын бага ангитай 18 сургууль 100 хувь ажлын 5 өдөр халуун хоолоор үйлчилж байна. Төслийн судалгааны үд дүнд үндэслэн аймгийн Засаг даргын санаачилгаар аймгийн 18 сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад “Сүү” хөтөлбөрийг 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж, хичээлийн 5 өдрийн 3 өдөр нь нэмэлтээр 1 хүүхдэд 120 мл сүүг өгч байна. Энэхүү “Сүү” хөтөлбөрийн зардлыг

аймаг, сумын засаг дарга нар, эцэг эхчүүд хамтран шийдвэрлэж байгаа бөгөөд иргэд эцэг эхчүүд маш талархалтай байна. Сүү хөтөлбөрт 156,0 сая, ширээ сандалд 30,0 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэсэн байна.



Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 2.7 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээн авсан.

3. ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР /ДУНДГОВЬ, САЙНЦАГААН СУМ, 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ/

ХҮЧИН ЧАДАЛ:
150 ор

БАЙРШИЛ:
Дундговь аймгийн, Сайнцагаан сум

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: /СЯЯ төг/:
2,710.0 сая төгрөг

ГҮЙЦЭТГЭГЧ:
"Энх баялаг констракшн" ХХК

ЗУРАГ ТӨСӨЛ ГҮЙЦЭТГЭГЧ:
"Бес онцгой дизайн" ХХК

ГЭРЭЭНИЙ ЭХЛЭХ, ДУУСАХ ОГНОО:
2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
2023 оны 11 дугаар сарын 27-ны өдөр

АЖТЫН ЯВЦЫН ХУВЬ: 100%

Дэлгэрцогт суманд 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг Улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтаар барилга угсралтын ажлыг "Ашид бьюлдинг" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний боловсролын салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 93.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар зорилт тус бүрээр харуулбал:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Шалгуур үзүүлэлт	44	92.2
2	Засаг даргын хүлээх үүрэг	74	95.4
3	Дүн	118	93.8

Гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд 61.130.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд улсын төсөв 58.357.2 сая, орон нутгийн төсөв 2,528.30 сая, төсөл хөтөлбөр 37.70 сая, хандив тусламж 207.0 сая төгрөг байна.

Аймаг 2023 оныг “Боловсролын чанар хүртээмжийг дэмжих” жил болгон зарлаж, Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах, Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд боловсролын салбарт 1,199.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр гэрээгээр хүлээх үүргийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Хэрэгжилт удаашралтай болон тасарсан заалтууд

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь	Удаашралтай байгаа шалтгаан
1	3.2.8 Сургалтын байгууллагын интернэт холболтыг сайжруулах, ухаалаг төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх	Дундговь аймгийн хэмжээнд 16 дотуур байр байгаагаас 10 дотуур байр нь сүлжээнд холбогдсон.	66.6	Үлдсэн 6 дотуур байр шинэ байр ашиглалтад орохыг хүлээх мөн тоног төхөөрөмжийг худалдан авахаар захиалгаа өгөх зэрэг асуудлаар хүлээгдэж байна.
2	3.2.15. Цэцэрлэг, сургуулийн сурагчдын эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэгийн орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын	Ерөнхий боловсролын сургуулийн 16 дотуур байрнаас 14 дотуур байр буюу 87,5 хувь нь дотор нойл болон гар угаах нөхцөл бүрдээд байна.	66.6	ариун цэврийн байгууламж 8 суманд 3 дугаар ээлжид ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэлийн 70 хувьтай байна. Дэлгэрцогт сумын ариун цэврийн байгууламж дахин суугдаагүй ашиглалтад хүлээж аваагүй удаашралтай байна.

	бодисын хангамжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих			
3	3.3.3 Цэцэрлэг, ерөнхий болон мэргэжлийн боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар хангах, ажлын байранд нь мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг чанартай зохион байгуулах	Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 94,6 хувь байна. Энэ нь өмнөх оны энэ үеийнхтэй харьцуулахад 1,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна	75	Энэ сургуулийн өмнөх боловсролын багш улсын хэмжээнд дутагдалтай байгаатай холбоотой байна.
4	3.3.4. Төсөв, санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлийг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлэх, дотоод аудитын болон хяналтын тогтолцоог тогтмол ажиллуулах	Салбарын 41 байгууллага шилэн дансны мэдээ мэдээллийг сар, улирал, жилээр бүрэн байршуулж ажилласан байна. Хагас жилээр аймгийн ХШҮ-тэй хамтарсан шалгалтыг хийж, 1-р улирлын байдлаар 70 хувьтай байсныг сайжруулан жилийн эцсээр 100 хувьд хүргэж ажиллалаа. 2023 оны 10 сард 14 сумын сургууль цэцэрлэгээр зөвлөн туслах ажлын хүрээнд төсвийн 2, байгууллагын нягтлан 1 нийт 3 санхүүгийн ажилтан зөвлөн туслах 3 багийн бүрэлдэхүүнд орж, салбарын байгууллагын шилэн данс, сурах бичиг, бусад хөрөнгө, санхүүгийн баримт, нярвын ажлыг газар дээр нь танилцаж зөвлөгөө өгч ажилласан байна.	65	Төлөвлөхдөө 100 хувьд хүргэнэ гэж төлөвлөснөөс Шилэн дансанд 41 байгууллага давхардсан тоогоор 5699 мэдээлэл оруулахаас 5663 мэдээлэл оруулж шилэн дансны хэрэгжилт 99.3 хувьтай байна
5	3.3.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар солих төслийн 4-р ээлжид бүрэн хамрагдах судалгаа, тооцооллыг үнэн зөв гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах	ЕБС, СӨБ-ийн ариун цэврийн байгууламжийн 1,2-р ээлжийн 9 объектын барилга угсралтын ажлын явц 100 хувь, 2023 онд Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр 10 байгууламж 80-100 хувь, 2 байгууламж 50 хувь, 3 байгууламж 5 хувь, 1 байгууламж 0 хувийн гүйцэтгэлтэй байна. 7 ариун цэврийн байгууламж ашиглалтад ороод байна.	66.6	3-р ээлжийн 16 объектын барилга угсралтын ажлын 70 явц хувьтай байна. Ариун цэврийн байгууламжийн 4-р ээлжид Эрдэнэдалай сумын цэцэрлэг 2, Баянжаргалан сумын сургууль 1, дотуур байр 1 нийт 4 объект байгаа бөгөөд зураг төслийн ажил явц 80 хувьтай, магадлалд өгөх шатандаа явж байна.
6	3.4.1.1. Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх	БШУЯ-наас ЕБС, цэцэрлэгийн хүнс хангамжийн асуудлыг хамтран шийдвэрлэх, хагас боловсруулсан бүтээгдэхүүн нийлүүлэх Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шалгаруулалтад Дундговь Политехник коллеж холбогдох судалгаа, тооцооллыг боловсруулан оролцож сонгогдон 74.8 сая төгрөгийн өртөг бүхий 40 нэр, төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авч ЕБС, цэцэрлэгт хоолны бэлдэц буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн	50	Политехникийн коллежтой хамтран Инновац шингэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн тоо 3 болгоно гэсэн нь удаашралтай заалт болсон.

		нийлүүлэх боломжтой болсон.		
7	3.4.1.2 Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурлан инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан технологийн төсөл сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх	Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан технологийн төсөл сонгон шалгаруулж, хэрэгжилтийг хангах 2 арга хэмжээг зохион байгуулсан. Малчдын зуны улирлын ажлын ачааллыг бууруулах хонины ноосыг бага цагт үр дүнтэй ажиллах хонины ноос хяргах хайчтай машин зохион бүтээсэн нь ноосыг уртаар нь болон бүтнээр нь хаягдалгүй авснаар нэг малаас авах ноосны гарц нэмэгдэх нөгөө талаар ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд бүтээгдэхүүний чанар сайжран нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарган авах нөхцөл бүрдлээ. Сайнцагаан сумын иргэн А.Эрдэнэцог "Мөнхийн зун" улаан буудайн тэжээл тариалах ажлыг 5 сараас туршин, 11 сард 300 кв метр талбайгаас 14 хоногийн хугацаанд 4 тонн ургац хураан авсан нь аймаг орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурлан онцлог шинэ инновац шингээсэн бүтээгдэхүүнийг гарган авч чадлаа.	50	Шинэ хөдөө төслийн хүрээнд хөрөнгийн асуудал шийдэгдэн явж байгаад тодотголоор хасагдан зарим хөрөнгийг авах боломжгүй болсон. Харин 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан.
8	3.5.3. Ерөнхий боловсрол, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилан хэрэгжүүлэх;	2023 онд 26 байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 322.2 сая төгрөгийн өртэй гарсан. Үүнд: түлш халаалтын зардалд ерөнхий боловсролын 15 сургууль 276.4 сая төрөг, сургуулийн өмнөх боловсролын 9 байгууллага 43.1 сая төгрөг. Цэвэр бохир усны зардалд 2 сургууль 2.5 сая төгрөг. Урсгал засварын зардалд 53 цэцэрлэг, 3 сургууль 7.1 сая төгрөгийн өр тус тус үүсээд байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад өрийн хэмжээ 4 дахин, байгууллагын тоо 16-р нэмэгдсэн байна. Энэ нь өнгөрсөн 5-р сард халаалтын тариф нэмэгдсэн, дээрх нэмэгдэл нь төсөвт суугдаагүйтэй шууд холбоотой юм. Өрийн мэдээллийг сум, болон аймгийн төрийн санд мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.	66,6	Өр үүсгэхгүй ажиллана гэсэн нь тогтмол зардлын халаалтын тариф нэмэгдсэнээс халаалтын өр үүссэн.
Хавсралт шалгуур үзүүлэлт				
1	Бага, дунд боловсролын чанарын дундаж үнэлгээ, хувиар	Зорилтот түвшин 43. Хүрсэн түвшин 35.12	0	Чанарын дундаж үнэлгээгээр үнэлэгдсэн
2	Тухайн орон нутгаас ДБСБ-д тэргүүлэх болон эрэлттэй	Зорилтот түвшин 40.5 Хүрсэн түвшин 15	37	Зорилтот түвшиндээ хүрээгүй.

	мэргэжлээр элсэн сурсан элсэгчийн нийт элсэгчид эзлэх жин			
3	Бие даан олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлж, баталгаажуулсан иргэний тоо	Зорилтот түвшин 50 Хүрсэн түвшин 0	0	Насан туршийн боловсролын төвийн багш байхгүйгээс сургалт зохион байгуулагдаагүй байна

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Боловсрол шинжлэх ухааны газарт

1.Гэрээнд тусгагдсан үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

2.Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх


3.Дараа оны гэрээний төсөлд төсөв хөрөнгө нь тодорхой, үр дүн гарахуйц бодитой ажлуудыг тусгах саналыг яам руу уламжлах

4.Хэрэгжилт удаашралтай байсан арга хэмжээнүүдийг байгууллагын 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Б.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг